

“Эм Эн Ай” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл  
Ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх  
тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 38.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Эм Эн Ай” ХХК-ийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг гаргасан зөрчлөө арилгаж зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны 2007 оны 135 дугаар тогтоолын хавсралтад заасны дагуу төвлөрүүлж дуусгах хүртэлх хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2.Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн өдрөөс хойш 3 сар хүртэл хугацаанд гаргасан зөрчлөө арилгаагүй бол олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авах болохыг “Эм Эн Ай” ХХК /И.Энхтөвшин/-д анхааруулсугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ